



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 81
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЦОЛМОН ТАНАА

**2021 оны санхүүгийн тайлангийн
аудитын зөвлөмж хэрэгжүүлж
ажиллах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 3,139.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгч байна.

Илрүүлэлт: Цагийн бүртгэлийн дэвтэр, хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмжийн бүртгэл, чөлөөний хуудас зэрэг анхан шатны нотлох баримтуудад үндэслэлгүй албан хаагчдад цалин олгосон байна. Энэ нь хөдөлмөрийн тухай хуулийн 107.1-д "Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно.", байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.4-д "Ажилтан нь ажилдаа өглөө ирсэн, ажлаас орой тарсан цагаа цаг бүртгэлийн төхөөрөмжөөр өөрөө бүртгүүлнэ. Ажлын цагийн бүртгэл ажилтны ажлын цагийн ашиглалтын байдалд газар, хэлтсийн дарга хяналт тавьж ажиллана. Ажлын цагийн бүртгэлийн нэгтгэлийг мэдээлэл технологийн ажилтан 7 хоног бүр гарган Газрын даргын удирдлагын хэлтсийн даргаар батлуулна. Батлагдсан нэгтгэл буюу цагийн балансыг үндэслэн нягтлан цалинг бодож олгоно", 10.5-д "Ажилтан нь ажлын цагийн дундуур хариуцсан ажлын шаардлагаар өөр байгууллагад /гадуур/ ажиллах үед хариуцсан газрын даргад мэдэгдэж гадагш ажилд явах тухайгаа бүртгэлийн дэвтэрт тодорхой тэмдэглэнэ. Бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийгээгүй бол ажил тасалсанд тооцон цалингаас хасах арга хэмжээг авна. Ажлаас хожигдсон, ажлын цаг дуусахаас өмнө ажил хаяж явах, цагаа бүртгүүлээгүй хугацааг нэгтгэх зарчмаар ажил тасалсан өдрийг тооцно.", 10.7-д "Ажилтны цагийн бүртгэл нь тухайн ажилтанд цалин хөлс олгох баримт болно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны нотлох баримтуудад үндэслэж цалин хөлс олгож байх.

Илрүүлэлт: ГХБХБГ-ын дарга Д.Цолмон 2021 оны 03 сарын 10-аас 13-ны өдрүүдэд, 09 сарын 02-оос 09 сарын 06-ны өдрүүдэд Улаанбаатар хотод

томилолтоор явсан хэдий ч жолоочийн тооцооны хуудаст тус өдрүүдэд Орхон аймагт ажилласнаар бүртгэсэн байна. Жолоочийн тооцооны хуудсыг хуурамчаар хөтөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6, 13.7 дахь хэсгүүдийг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын үнэн зөвийг нягталж, санхүүгийн тайланд тусгаж байх.

Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант хугацаанд нийт 3,139.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, худалдан авсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ